

ГОНКОНГТ ХИЙСЭН ТЭМДЭГЛЭЛ

*Д.Эрдэнэ-Отгон**

“АНУ-ын гадаад бодлого дахь Конгрессийн үүрэг роль” сэдэвт Азийн Америк судлаачдын семинар 2002 оны 8-р сарын 4-10 ны өдрүүдэд Гонконгт болов. Семинарыг Гонконгийн Америк судлалын төв (Hong-Kong America center), Гонконгийн Хотын Их Сургууль (City University of Hong-Kong) зохион байгуулав. Семинарт БНСУ, Филиппин, Монгол, БНХАУ, Индонези, Япон, Малайзи, Тайланд, Тайвань, Гонконгийн зэрэг Азийн орнууд болон Тайвань Гонконгийн 25 эрдэмтэн судлаачид оролцсон юм. Семинарыг АНУ-аас уригдаж ирсэн АНУ-ын Конгрессийн болон гадаад бодлогоор мэргэшсэн нэртэй эрдэмтэд болох Чарльз Тиен, Жеймс Натан нар хөтлөн явуулсан нь семинарын ач холбогдлыг өндөрт өргөж байлаа. Ер нь семинар нь ажил хэрэгч, ил тод, зохион байгуулалт сайтай маш сонирхолтой болсон.

7 хоногийн турш үргэлжилсэн семинар нь гол асуудал болох “Конгресс АНУ-ын гадаад бодлогод ямар үүрэг рольтой, яаж нөлөөлдөг вэ гэсэн?” асуултанд хариу өгч Конгрессийн дотоод бүтэц, түүний бусад байгууллагатай хэрхэн уялдаа холбоотой ажилладаг, мөн АНУ-ын гадаад бодлого ялангуяа, Азийн орнууд руу хэрхэн чиглэгдэж байгаа талаар тун нухацтай, илэн далангүй ярилцав. Тус семинар нь:

- Конгрессийн гишүүд хэрхэн яаж сонгогддог болон сонгогдсон гишүүд АНУ-ын гадаад бодлогод хэрхэн нөлөөлдөг
- Конгрессийн гадаад бодлогыг тодорхойлоход улс төрийн намууд, тэдгээрийн лидерүүдийн үүрэг ролийн тухай
- Эрх ашиг сонирхлоороо нэгдсэн улс төрийн сонирхолын бүлэглэлүүдийн үүрэг роль, сонгуулийн санхүүжилт зэрэг олон арван сонирхолтой асуудлын талаар тодорхой хэмжээний ойлголт семинарт оролцогчид өглөө.

Түүнээс гадна Азийн олон орны төлөөлөгчид сэдэвтэйгээ уялдуулан өөрийн орны улс төрийн систем, гадаад бодлого зэрэг сэдвээр ярилцаж санал бодлоо чөлөөтэй илэрхийлж байлаа.

* Д.Эрдэнэ-Отгон - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

Одоо би тус семинарыг зохион байгуулагчидийн нэг болох Гонконг Америкийн харилцаанд чухал үүрэг гүйцэтгэгч Гонконгийн Америкийн төвийн (Hong-Kong America Center) болон Гонконг Америкийн харилцааны талаар товчхон өгүүлье.

Хувийн, ашгийн бус байгууллага Гонконг-Америкийн төв нь 1993 онд Гонконгод байгуулагджээ. Тус төв нь өөрийн гишүүн Их сургууль, Гонконг, АНУ-ын ивээн тэтгэгч байгууллагууд болон өөрсдийн хэрэгжүүлдэг төслийн грант, гэрээ контракт зэргээс санхүүждэг байна.

АНУ болон Гонконгийн засгийн газартай уялдаа холбоотой ажилладаг Гонконг-Америкийн төв нь оюутан эрдэмтэн багш нарын солилцоог асуудлыг зохион байгуулж, тэдгээрийн сурах багшлах, судалгааны ажил хийх зэрэг туслалцаа үзүүлдэг байна. Тус төв нь Гонконгийг сурах, амьдрах нөхцөлөөр хангагдсан хүний сэтгэл татам сайхан газар гэдэг талаас нь Америкийн их дээд сургуулиудад сурталчлахаас гадна нөхөрлөлийн программыг зохион байгуулж Гонконгийн залуу судлаачдыг АНУ-д очих боломж олгодог зэрэг олон арван сонирхолтой ажил үйлс явуулдаг бөгөөд Америк Гонконгийн харилцаанд чухал үүрэг гүйцэтгэдэг юм байна.

Гонконг – Америкийн харилцаа нь гүнзгий бөгөөд ээдрээтэй юм. Гонконг, Америкийн мянга мянган хүмүүс Хятад Америкийн соёлыг хамтад нь маш өвөрмөц бүтээлч шатанд гарган хөгжүүлсээр иржээ. 55,000 гаруй америкчууд Гонконгд сурч амьдарч байдаг бол 75,000 хүн жил бүр Гонконгт ирж очдог байна. Америкт буй хятад хүмүүсийн талаас дээш хувь нь Гонконгоос гаралтай ажээ. Жил бүр 10,000 гаруй Гонконг оюутан, сурагчид Америкийн их, дээд сургуулиудад суралцдаг бол Америкт боловсрол эзэмшсэн 100,000 хүн АНУ-аас буцаж ирэн эх нутгийнхаа хөгжил цэцэглэлтэд хувь нэмрээ оруулж байдаг байна.

Гонконг Америкийн бизнес худалдааны чиглэлийн харилцаа жилээс жилд өсөн нэмэгдэж цар хүрээгээ улам өргөжүүлж байгаа гэнэ. Америкийн 1,100 гаруй компани Гонконгд худалдааны төлөөлөгчийн газраа нээж ажиллуулсан бөгөөд тэдгээр нь Америкийн худалдааны гарцыг БНХАУ-д нээж өгдөг юм байна. Хоёр талын худалдааны эргэлт жил бүр 25 тэрбум ам.долларт хүрч АНУ нь Гонконгийн бараа бүтээгдэхүүний маш том зах зээл болсоор байгаа ажээ. Америкийн 15 дахь худалдааны томоохон түншийн хувьд Гонконг нь АНУ-аас жил бүр 15 тэрбум долларын бараа бүтээгдэхүүнийг импортолдог байна. Америкчууд Гонконгд 21 тэрбум ам.долларын шууд хөрөнгө оруулалт

хийсэн бөгөөд бэлэн бусаар хийгдсэн хөрөнгө оруулалтыг тооцвол тэрнээс ч их тоо гарах бизээ.

Шинжлэх ухаан технологийн салбарт ч Гонконг Америкийн харилцаа мөн өндөр шатанд хөгжиж байгаа нь харагдаж байна. Гонконгчуудийн англи хэлний мэдлэг болон Интернетийг өргөн дэлгэр ашигладаг нь Гонконгчуудийг Америкчуудтай чөлөөтэй харилцах боломжийг олгодог юм байна. Гонконгийн их дээд сургуулиуд, соёлын байгууллагуудын америк боловсрол олсон олон удирдагчид тус хотыг Азид шинжлэх ухаан соёлын томоохон төв болоход чухал үүрэг гүйцэтгэж ирсэн юм.

Гонконг Америкийн харилцаа нь эдийн засгийн үндэс, улс төрийн ирээдүй, соёлын цэцэглэлт зэрэгт маш чухал үүрэгтэй юм байна. АНУ-ыг Азитай тэр тусмаа БНХАУ-тай холбож өгдөг хамгийн шилдэг гүүрийн хувьд Гонконг нь мөн Азийн орнууд болон Америкийн хооронд соёлын харилцааг бий болгож байдаг онцлогтой бөгөөд БНХАУ-тай эдийн засаг нийгмийн харилцааны хувьд улам бүр нэгдэж байгаа нь Гонконг-Америкийн харилцааг бүр ч чухал болгож байгаа юм.

Миний хувьд энэхүү семинарт оролцсоноор их зүйлийг мэдэж авлаа. Эрдэм судлалын ажил хийхэд үндсэн суурь мэдлэгээс гадна дэлхий дахины сонин соргог мэдээ сэлт, сонгосон сэдвээ ил тод байдалд марган хэлэлцэх байдал хэрэгтэй юм байна гэдгийг ухаарсан. Ялангуяа Монгол-Америкийн харилцааны асуудлаар эрдмийн ажил эхлэн оролдож буй миний хувьд уг семинарт оролцсон нь их завшаан болов. Семинарт оролцуулахаар явуулсан хүрээлэнлэнгийнхээ захиргаанд, АНУ-ын элчин сайдын яаманд талархсанаа илэрхийлье.